



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ



# МОНГОЛЫН ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУНДАХ ЦАХИМ ДЭЭРЭЛХЭЛТИЙН ТАЛААРХ СУДАЛГАА

---

## ТАЙЛАН

2025 ОНЫ 3-Р САР

---

## ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг боловсруулж, эцэслэн гаргах ажилд хувь нэмрээ оруулсан Мэдээллийн системийн аюулгүй байдлын мэргэжилтэн (CISSP) доктор Ууганбаярын Ганбаяр; CISSP, Мэдээллийн системийн аудитын мэргэшсэн аудитор (CISA) Чулуунбаатарын Сэлэнгэ; Хакерын ёс зүйн мэргэжилтэн (CEH) Тулгабаатарын Нямжаргал; Шинжлэх Ухааны Магистр Түмнээгийн Тэлмүүн; мөн Магистр Бат-Оргилын Жаргалан нарт гүн талархал илэрхийлье.

Мөн энэхүү судалгааг олон нийтэд түгээж, цахим аюулгүй байдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулсан Агула даатгал ХХК, CySec Taimens ХХК-д чин сэтгэлийн талархал илэрхийлье. Түүнчлэн цахим аюулгүй байдлын судалгаанд оролцсон Мягмардоржийн Халиунаа, тоглоомчилсон хандлагын талаарх зөвлөмж өгсөн Ганбатын Батжаргал, мэдээллийн аюулгүй байдлын ойлголт судлалд хувь нэмэр оруулсан Батжаргалын Энхбаяр нарт талархаж буйгаа илэрхийлье. Цахим аюулгүй байдлын контент бэлтгэлд оролцсон Пүрэвдоржийн Баясгалан, Алтангэрэлийн Ангараг, Бүрмаагийн Сендэр, CySec Taimens ХХК-ийн гүйцэтгэх захирал Ууганбаярын Ганзориг нарт талархал дэвшүүлж байна.

Мөн энэхүү судалгааны ажлыг хэрэгжүүлэх явцад хамтын ажиллагаа, бодлогын дэмжлэг үзүүлсэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газарт гүн талархал илэрхийлье. Тэдний оролцоо нь судалгааны үр дүнг бодлогын түвшинд тодорхойлох, үндэсний цахим аюулгүй байдлын чадавхыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан болно.

Тус судалгааны ажлын туршид үнэтэй зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, урам өгсөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Бангкок төвийн Бүсийн инновац, дижитал багийн Дэд бүсийн дижитал мэргэжилтэн Ражарши Чаттержи-д гүн талархал илэрхийлье.

Судалгаанд хувь нэмэр оруулсан бүх мэргэжилтнүүдийн тусламжтайгаар бид цахим аюулгүй байдлын талаарх олон нийтийн ойлголт, хууль, зохицуулалт, аюулгүй байдлын ерөнхий арга хэмжээ, холбогдох талуудын оролцоог үнэлэх, улмаар цахим эринд хувь хүний аюулгүй байдлыг (цахим болон цахим бус орчинд) бэхжүүлэх зорилготой бүрэн судалгааг хийж гүйцэтгэлээ.

Эцэст нь, энэхүү судалгаанд сайн дураараа оролцсон бүх хүмүүст талархал илэрхийлье.

---

## ЕРӨНХИЙ МЭДЭГДЭЛ

Энэхүү тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) бэлтгэн гаргасан болно. Энэхүү хэвлэлд ашигласан нэршил, материалууд нь НҮБХХ болон тухайн улсын зүгээс ямар нэгэн албан ёсны байр суурь илэрхийлээгүй болно. Энэхүү хэвлэлд илэрхийлэгдсэн агуулга, үзэл бодол нь зохиогчдынх бөгөөд хамтран нийтлэгч байгууллагуудын албан ёсны бодлого, үзэл баримтлалтай нийцнэ гэсэн баталгаа биш юм. Хэвлэн нийтлэгч байгууллага энэхүү хэвлэлд

багтсан мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулахгүй бөгөөд тэдгээрийг ашигласны улмаас үүсэх аливаа үр дагаварт хариуцлага хүлээхгүй. Тодорхой газар нутаг, бүс нутгийг нэрлэх, эсвэл “улс” гэх нэр томъёог ашигласан нь тухайн газар нутгийн хууль эрх зүйн эсвэл өөр ямар нэгэн статустай холбоотой аливаа үнэлгээ, дүгнэлт хийх зорилготой биш болно.

© НҮБХХ 2025 Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

*НҮБХХ нь энэхүү мэдээллийг зөвхөн хувийн бөгөөд ашгийн бус зорилгоор, зохих эх сурвалжийг дурдсан нөхцөлтэйгөөр хэвлэх, хуулбарлахыг дэмждэг. Харин НҮБХХ-ээс бичгээр зөвшөөрөл авалгүйгээр дахин худалдах, түгээх, эсвэл арилжааны зорилгоор дахин боловсруулахыг хориглоно.*

Цахимаар мөн үзэх боломжтой: <https://www.undp.org/mongolia>

Нэмэлт мэдээлэл шаардлагатай бол дараах хаягаар холбогдоно уу:

Нэгдсэн Үндэстний Байгууллага – Монгол дахь төлөөлөгчийн газар  
НҮБ-ын байр, НҮБ-ын гудамж-14, Сүхбаатар дүүрэг, 14201,  
Улаанбаатар, Монгол Улс

Утас: +976-11-327585

---

## АГУУЛГА

Талархал .....	2
Анхааруулга .....	3
1. Ерөнхий тойм .....	5
2. Танилцуулга .....	7
3. Цахим дээрэлхэлт ба төрлүүд.....	8
4. Монгол улсын одоогийн хууль зүйн орчин.....	9
5. Цахим дээрэлхэлтийн тухай статистик.....	11
6. Цахим дээрэлхэлтийн талаарх судалгаа .....	12
6.1. Судалгааны арга зүй.....	12
6.2. Ёс зүйн стандарт .....	14
6.3. Үр дүн .....	15
7. Олон улсын сайн туршлага.....	23
8. Дүгнэлт ба Зөвлөмж .....	25
9. Уриалга.....	29
Ном зүй.....	30

# 1. ЕРӨНХИЙ ТОЙМ

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Хурдасгуур Лаборатори нь Монголын хүүхэд, өсвөр үеийнхний дунд цахим дээрэлхэлтийн тулгамдсан асуудлыг судлах зорилгоор энэхүү судалгааг санаачлан эхлүүлсэн. Уг судалгааны гол зорилго нь цахим дээрэлхэлтийн түвшин, нөлөөллийг үнэлэх, хүүхэд болон эцэг эхчүүдийн мэдлэг, ойлголтын түвшинг тодорхойлох, цаашид энэ асуудлыг шийдвэрлэх боломжит арга замуудыг тодорхойлоход чиглэсэн юм.

Судалгааг найдвартай, өргөн хүрээний төлөөллийг оролцуулахын тулд Улаанбаатар хотын 12 улсын болон хувийн сургуулийн нийт 5,477 оролцогчийг хамруулсан. Үүнээс 1,620 нь эцэг эх, 3,857 нь сурагч байсан бөгөөд сурагчдыг 9–12 болон 13–17 насны хоёр үндсэн бүлэгт хуваасан. Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн дийлэнх нь 35–44 насныхан байсан бөгөөд 25–34, 45–54, 55-аас дээш насны эцэг эхчүүд ч мөн зохих хэмжээнд төлөөлөгдсөн. Оролцогчдын олон талт байдал нь судалгааны үр дүнг илүү гүнзгий ойлгоход тустай бөгөөд цаашид зөвлөмжийг нарийвчлан боловсруулахад чухал үүрэгтэй юм.

Судалгааны үр дүнд цахим дээрэлхэлтийн асуудал Монголын хүүхэд, залуучуудын дунд өргөн хүрээтэй, ноцтой асуудал болох нь тодорхойлогдсон. 9–12 насны хүүхдүүдийн ойролцоогоор гуравны нэг нь, харин 13–17 насны өсвөр үеийнхний 51.3% нь доромжлол, зарим тохиолдолд цахим дээрэлхэлтийн улмаас бэлгийн дарамтад өртөж хохирогч болж байгаа нь судалгаагаар тогтоогдсон. Түүнчлэн судалгаанд оролцсон хүүхдүүдийн 90% нь Facebook ашиглах насны шаардлага хангаагүй хэдий ч тогтмол ашигладаг гэж хариулжээ. Үүнээс онцлох нэг зүйл нь цахим дээрэлхэлтэд өртсөн хүүхдүүдийн тал орчим хувь нь энэ тухайгаа хэн нэгэнд мэдэгддэггүй нь хүүхдүүд, насанд хүрэгчдийн хооронд итгэлцэл, харилцааны асуудал байгааг илтгэнэ.

Судалгаа нь мөн эцэг эхчүүдийн цахим мэдлэгийн түвшин, сургуулийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд нэлээд дутагдалтай байгааг харуулж байгаа юм. Эцэг эхчүүдийн гуравны нэгээс илүү нь олон нийтийн сүлжээ ашиглах насны доод хязгаарыг мэддэггүй, сурагчдын талаас илүү хувь нь сургуулиасаа цахим дээрэлхэлтийн талаар ямар ч мэдлэг, сургалт аваагүй байжээ. Энэ нь ялангуяа

өсвөр насныханд нойргүйдэл, сэтгэл гутрал, амиа хорлох тухай бодол зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн ноцтой асуудал үүсгэж буйг харуулж байна.

Цахим дээрэлхэлт нь Монголын хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэнд, амьдралын чанарт ноцтой нөлөө үзүүлж байгаа нь яаралтай анхаарал хандуулах, хариу арга хэмжээ шаардсан ноцтой асуудал болоод байна. Цахим дээрэлхэлтийн хохирогчид түгшүүрт эмгэг тусах, хэт гуниглах, өөрийгөө үнэлэх үнэлэмж буурах зэрэг сөрөг сэтгэл хөдлөлийг мэдэрч, энэ нь тэдний хувийн амьдрал болон сурлагад урт хугацааны сөрөг нөлөө үзүүлдэг байна. Энэхүү судалгаа нь эцэг эхчүүдэд зориулсан боловсролын нөөц боломжийг сайжруулах, олон нийтийн мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэх, хүүхэд өсвөрийнхний сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах шаардлагатайг онцолж байна.

Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд судалгаа дараах цогц арга хэмжээнүүдийг санал болгож байна:

Эцэг эхчүүдэд зориулсан цахим дээрэлхэлтийн талаар боловсрол олгох сургалтын материал, мэдээллийг боловсруулж түгээх, ингэснээр хоёр жилийн дотор эцэг эхчүүдийн мэдлэгийг 50%-иар нэмэгдүүлэх зорилготой.

9–17 насны бүх сурагчдад зориулсан цахим дээрэлхэлтийн талаарх мэдлэг олгох болон цахим боловсролын хөтөлбөрүүдийг сургалтын хөтөлбөрт бүрэн нэгтгэх, улмаар дараагийн хичээлийн жил дуусахад сургуулиудын 90% нь жил бүр уг сэдвийн хүрээнд сургалт, үйл ажиллагааг зохион байгуулдаг болох.

Цахим дээрэлхэлтийн хохирогч болсон хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан, насанд нь тохирсон сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ бий болгох, үүний үр дүнд дээрэлхэлтийн тухай мэдээлж буй хүүхдүүдийн 80%-д шууд тусламж үзүүлэх, мөн амиа хорлох бодолтой сурагчдын эзлэх хувийг хоёр дахин бууруулах.

Сургууль болон орон нутгийн хэмжээнд цахим дээрэлхэлтийг мэдээлэх механизм болон дэмжлэгийн тогтолцоог сайжруулах, ингэснээр хүүхдүүд өөрсдийн эрх ашгаа хамгаалан мэдээлэл

өгөх итгэлтэй байдлыг нэмэгдүүлэх.

Энэхүү судалгаа нь Монголын хүүхэд, өсвөр үеийнхний дунд газар авч буй цахим дээрэлхэлтийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хамтын ажиллагаанд суурилсан, олон талт оролцоог шаардлагатай болохыг онцолж байна. Судалгаанаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж, эцэг эх, багш, сэтгэл зүйчид болон орон нутгийн удирдлагууд зэрэг гол оролцогч талуудыг идэвхтэй оролцуулснаар

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь Монголын хүүхэд, өсвөр үеийнхний хувьд аюулгүй, тэднийг дэмждэг цахим орчин бүрдүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорьж байна. Энэхүү чухал асуудлыг шийдвэрлэхийн тулд нэгдмэл хүчин чармайлт гаргаж, хамтын үнэт зүйлстэй хандсан тохиолдолд тэдний сайн сайхан, эрүүл мэндийг хамгаалж чадах юм.

## 2. ТАНИЛЦУУЛГА

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад цахим шилжилт хурдацтай өрнөж, нийгэм, эдийн засгийн бүтэц үндсээрээ өөрчлөгдөж байна. Цахим технологийн хөгжил нь харилцаа холбоо, боловсрол, эдийн засгийн хөгжилд шинэ боломжуудыг бий болгож, олон талын ашиг тусаа өгсөн. Гэвч энэхүү хувьсал нь мөн олон талт цахим аюулгүй байдлын асуудлуудыг дагуулж буй бөгөөд ялангуяа залуу үеийн дунд цахим дээрэлхэлтийн түгээмэл байдал нэмэгдэж байгаа нь хамгийн ноцтой сорилтуудын нэг болоод байна.

Монгол Улсын цахим орчны уялдаа, холбоо нэмэгдэж, онлайн үйл ажиллагаа эрчимтэй өсөхийн хэрээр хувийн мэдээлэл алдагдах, халдлагад өртөх, цахим луйвар, цахим дээрэлхэлт зэрэг аюулд өртөх эрсдэл улам бүр нэмэгдэж байна. Уламжлалт дээрэлхэлт буюу бие махбодын хүчирхийлэл, үгээр доромжлох, нийгмээс тусгаарлах зэрэг хэлбэрүүд одоо ч өргөн тархсан хэвээр байгаа бөгөөд үүнийг нотлох баримт нь 1–14 насны хүүхдүүдийн 47% нь гэртээ болон сургууль дээрээ хүч хэрэглэсэн сахилгын арга хэмжээнд өртдөг гэсэн тоо юм (UNICEF, Хүүхэд хамгаалал, 2013). Гэсэн хэдий ч цахим платформуудын гарч ирснээр энэ төрлийн сөрөг үйлдлүүд улам хүчтэй, хурдтай, өргөн цар хүрээтэй болсон. Ялангуяа цахим дээрэлхэлт нь халдварт өвчин мэт тархаж, онлайн сүлжээний хурд, хүртээмжийг ашиглан доромжлол, сүрдүүлэг, нийгмээс тусгаарлалт зэрэг хортой зан үйлүүдийг урьд өмнө байгаагүй хэмжээнд түгээж байна.

Эдгээр хурдацтай нэмэгдэж буй сорилтуудыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар цахим аюулгүй байдлын дэд бүтцийг бэхжүүлэхэд чиглэсэн идэвхтэй алхмуудыг авч хэрэгжүүлж байна. 2022 онд батлагдсан “Кибер аюулгүй байдлын тухай хууль” болон “Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги” нь Монгол Улс кибер орон зайд хөрөнгөө хамгаалах чухал ахиц гаргасныг илтгэнэ. Мөн “Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль” (хуучин “Хувийн нууцын тухай хууль”-ийг орлож байгаа) болон холбогдох бодлогууд нь Монгол Улсын хувийн мэдээлэл хамгаалах чиглэл дэх орчин үеийн олон улсын стандартад нийцсэн үүрэг амлалтыг улам бататгасан.

2024 оны 9 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн

шинэчилсэн найруулгад хүүхдийн эсрэг чиглэсэн цахим дээрэлхэлт болон хүүхдэд хортой агуулгатай контентын асуудлыг тусгайлан зохицуулсан заалтууд багтсан. Уг хуульд хүүхдийг урхидах, дээрэлхэх, дарамтлах зэрэг цахим орчинд үзүүлж буй аливаа сөрөг үйл ажиллагааг хориглосон бөгөөд үүгээр дамжуулан хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл санаа, хөгжлийг хамгаалахад чиглэсэн чухал алхам болсон.

Хууль эрх зүйн хувьд ахиц дэвшлүүд гарсан боловч үүний зэрэгцээ шийдвэрлээгүй хэд хэдэн чухал асуудлууд байсаар байна. Үүнд: технологи суурьтай жендерт суурилсан хүчирхийлэлийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, сэргийлэх, зохицуулах орчны дутагдалтай байдал, дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хүртээмжийн хязгаарлалт, цогц дата мэдээллийн хомсдол зэрэг багтана. Эдгээр дутагдлууд нь Монгол Улсын өргөжиж буй цахим орчинд хүүхэд, өсвөр үеийг бүх төрлийн дээрэлхэлтээс хамгаалахад чиглэсэн нэгдсэн, нотолгоонд суурилсан стратегийн нэн шаардлагатайг улам баталж байна.

Түүнчлэн, интернэтийн хэрэглээ нэмэгдсэнээр цахим дарамт шахалт, сэтгэл зүйн дарамт, донтолт зэрэг шинэ төрлийн эрсдэлүүд бий болсон нь Монголын залуучуудын сэтгэцийн эрүүл мэнд, өөрийгөө үнэлэх үнэлэмжид гүнзгий сөрөг нөлөө үзүүлж байна. Эдгээр эрсдэл нь ялангуяа эмэгтэйчүүд болон залуу үеийнхэнд илүү тод илэрч байгаа нь цахим шилжилт нь хүртээмжтэй байхаас гадна аюулгүй байх шаардлагатайг илтгэж байна.

---

*Харамсалтай нь интернет нь цахим дээрэлхэлт, цахим орчин дахь урхидах үйлдэл, донтолт зэрэг эрсдэлийг ч мөн дагуулж байна. Хүмүүсийн цахим орчинд шилжих хөдөлгөөн нэмэгдэхийн хэрээр эдгээр эрсдэлүүд улам бүр өсөн нэмэгдэж, ялангуяа эмэгтэйчүүд болон залуучуудын сэтгэцийн эрүүл мэнд, өөрийгөө үнэлэх үнэлэмж, итгэлцэлд ноцтой нөлөө үзүүлж байна. Тиймээс бид цахим шилжилт нь зөвхөн хүртээмжтэй байгаад зогсохгүй, аюулгүй байх нөхцөлийг бүрдүүлэх ёстой.*

*Матилда Димовска – НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь Суурин Төлөөлөгч*

---

# 3. ЦАХИМ ДЭЭРЭЛХЭЛТ БА ТӨРЛҮҮД

Цахим дээрэлхэлт нь технологиор дамжуулан (нийгмийн сүлжээ, мессежийн үйлчилгээ, онлайн тоглоомын орчин, гар утасны төхөөрөмжүүд зэрэг) үйлдэгддэг түрэмгий зан үйлийн нэг хэлбэр юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын сүүлийн үеийн судалгаагаар цахим дээрэлхэлтийг давтамжтай, санаатайгаар бусдыг айлгах, сүрдүүлэх, доромжлох, гутаан дорд үзэх, сэтгэл санааны хохирол учруулах зорилготой цахим үйлдлүүд гэж тодорхойлсон байдаг. Эдгээр үйлдэл нь ил болон далд хэлбэрээр явагдаж, хохирогчийг олон нийтийн болон хувийн цахим орчинд онилдог ба ихэнх тохиолдолд нотлох баримт болохуйц цахим мөр үлдээдэг. Цахим дээрэлхэлтийн нийтлэг хэлбэрүүдэд дараах зүйлс багтана:

- Худал мэдээлэл тараах: Хувь хүний нэр хүнд, харилцаанд хохирол учруулах зорилгоор худал цуурхал, гүтгэлэг, буруу мэдээллийг текст, эвлүүлсэн зураг, видео хэлбэрээр цахимаар тараах.
- Ичгэвтэр агуулга нийтлэх: Зөвшөөрөлгүйгээр хувийн зураг, видео, мэдээллийг нийтлэх, тараах замаар тухайн хүнийг доромжлох, шоолох.
- Гомдоосон мессеж эсвэл сүрдүүлэг илгээх: Давтан доромж, дорд үзсэн, сүрдүүлсэн үг, мессежийг шууд зурвас, сэтгэгдэл, пост хэлбэрээр илгээж, хохирогчид айдас, түгшүүр, дарамт мэдрүүлэх.
- Дүр эсгэх: Хуурамч хаяг үүсгэх эсвэл бусдын нэрийг ашиглан тэдний нэрийн өмнөөс хортой үйлдэл хийх, гутаах.

- Хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй тараах: Хувь хүний хувийн, нууц мэдээлэл (зураг, мессеж гэх мэт)-ийг тухайн хүний зөвшөөрөлгүйгээр олон нийтэд түгээх.
- Цахим тусгаарлалт хийх: Хүнийг санаатайгаар онлайн групп, чат, үйл ажиллагаанаас хасах замаар нийгмийн хувьд тусгаарлаж, сэтгэлзүйн хохирол учруулах.

Эдгээр хэлбэрүүд нь цахим орчны олон хэрэглэгч, цар хүрээтэй платформууд дээр илрэх боломжтой бөгөөд олон нийтийн болон хувийн орон зайн ялгаа зааг бүдгэрэх хандлагатай байдаг. Цахим контент устахгүйгээр хадгалагдах боломж, хурдацтай тархах шинж чанар нь хохирогчид үзүүлэх сөрөг нөлөөллийг улам нэмэгдүүлдэг. (UNICEF, *Cyberbullying: What is it and how to stop it*, 2024; UNDRR, 2020)

Урьд өмнө нь технологийн хүртээмж хязгаарлагдмал, ховор хэрэглээтэй байсан бол өнөөдөр Монгол Улсад, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхний өдөр тутмын амьдралын салшгүй нэг хэсэг болжээ. Хүүхэд, залуучууд боловсрол, зугаа цэнгэл, харилцаа холбооны зорилгоор компьютер, ухаалаг утас, интернетэд улам бүр хамааралтай болсон. Ийм цахим оролцоо нь суралцах, харилцах томоохон боломжийг олгож буй хэдий ч цахим дээрэлхэлт, дарамт, бусад эрсдэлд өртөх эрсдэлийг ч дагуулж байна. Иймд цахим дээрэлхэлтийг технологийн дэвшил, нийгмийн өөрчлөлтийн хамт хувьсаж байдаг олон талт сорилт хэмээн хүлээн зөвшөөрөх нь зүйтэй юм.

# 4. МОНГОЛ УЛСЫН ОДООГИЙН ХУУЛЬ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улс хүүхдийг цахим орчинд хамгаалах, цахим дээрэлхэлтийн эсрэг хариу арга хэмжээ авах эрх зүйн тогтолцоог бий болгох чиглэлээр чухал ахиц дэвшил гаргасан. Сүүлийн жилүүдэд батлагдсан хууль, бодлогын баримт бичгүүд нь цахим дээрэлхэлтийг зохицуулах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад шууд нөлөөлөх эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Монгол Улсад 2016 оны 2-р сарын 16-нд батлагдаж, 2024 онд шинэчлэгдсэн “Хүүхэд хамгаалах тухай хууль”-ийн 8 дугаар зүйлд “Хүүхдийг хэвлэл мэдээлэл, цахим орчинд хамгаалах” тухай тусгасан. Уг хуульд цахим дээрэлхэлттэй холбоотой дараах гол заалтууд багтсан:

- Хүүхэд сургууль, гэр бүл, цахим платформ зэрэг орчинд хортой, хориглосон агуулгад өртөхөөс хамгаалах, сэргийлэх.
- Хэвлэл мэдээлэл, нэвтрүүлэг болон цахим үйлчилгээ үзүүлэгчдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах үүрэг хүлээлгэсэн бөгөөд ингэснээр хүүхдийг цахим дээрэлхэлт болон бусад эрсдэлээс хамгаалах нөхцөл бүрдүүлж байна.
- Интернет үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу хүүхдэд зориулан хортой агуулгын тархалтыг хязгаарлах арга хэмжээ авах үүрэгтэй.
- Нэвтрүүлэг цацахын өмнө насны ангилал заасан тэмдэглэгээ байрлуулах шаардлагыг хуульчилж, насанд тохироогүй контентод хүүхэд өртөхөөс сэргийлнэ.
- Эцэг эх, асран хамгаалагчид нь хүүхдийг хориглосон болон хортой контент, түүний дотор цахим дээрэлхэлтээс хамгаалах хууль ёсны хариуцлагатай болохыг тодорхой тусгаж, гэр бүлийн үүрэг, оролцоог онцолжээ.

Энэхүү хууль нь хувь хүн болон байгууллагын үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байдлаараа цахим дээрэлхэлтийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох цогц эрх зүйн орчин болж байна. Мөн контент нийлүүлэгч болон гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг хуульчилж, цахим дээрэлхэлтэд өртөх, хохирохоос сэргийлэх хэрэгжих боломжтой механизмыг бүрдүүлжээ.

2022 онд батлагдсан “Кибер аюулгүй байдлын тухай хууль” нь Монгол Улсын цахим орчны аюулгүй байдлыг хангах үндэсний хүчин чармайлтын суурийг тавьсан. Тус хууль нь кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон хамгаалах чиг үүрэг бүхий зохицуулалттай бөгөөд цахим дээрэлхэлтийн эсрэг тэмцэлд чухал нөлөө үзүүлж байна. Цахим үйлчилгээ үзүүлэгчдийн үүргийг тодорхойлж, зөрчил гарсан тохиолдолд хамтран ажиллах, хариу арга хэмжээ авах тогтолцоог бэхжүүлснээр энэхүү хууль нь цахим дээрэлхэлтийг таниж илрүүлэх, хянах, зогсооход дэмжлэг үзүүлдэг. Мөн иргэд, тэр дундаа залуучуудыг цахим орчинд хариуцлагатай байхад чиглэсэн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдол өгч байгаа юм.

Мөн Үндэсний кибер аюулгүй байдлын стратеги 2022 онд батлагдсан бөгөөд Монгол Улсын цахим орчныг аюулгүй, тэсвэртэй болгох дунд хугацааны үзэл баримтлалыг тодорхойлсон. Уг стратеги нь цахим дээрэлхэлтийг цахим орчны аюулын нэг хэсэг гэж үзэж, урьдчилан сэргийлэх болон бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт кибер аюулгүй байдлын мэдлэг олгох агуулгыг тусгах, нэгдсэн төлөвлөлттэйгөөр хэрэгжүүлэхарга хэмжээг үндэсний бодлогын түвшинд нэгтгэхийг үүрэг болгосон. Ийнхүү цахим дээрэлхэлтийн асуудлыг тогтвортой бодлого, салбар хоорондын хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл болгон тодорхойлсон. Мөн 2022 онд батлагдсан “Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль” нь зөвшөөрөлгүй мэдээлэл түгээхийг гэмт хэрэгт тооцож, хүүхэд болон тэдний асран хамгаалагчдад цахим орчинд эрхээ хамгаалах эрх зүйн боломжийг олгож байна. Энэ нь хувийн мэдээлэл тараах, дүр эсгэх, хортой контент түгээх зэрэг үйлдлүүдийн эсрэг хамгаалалтыг ч бэхжүүлдэг. Үүнээс гадна Монгол Улсын Засгийн газар нь олон яам, агентлагийн хамтарсан зөвлөл, ажлын хэсгүүдийг байгуулж, цахим орчны хортой контентээс урьдчилан сэргийлэх, хамгаалах дэлгэрэнгүй журам, аргачлал боловсруулж, баталсан. Энэ үйл ажиллагаанд Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам зэрэг олон салбарын байгууллагууд хамтран ажиллаж буй нь нийтлэг, уялдаа бүхий хандлагын жишээ юм.

## 5. ЦАХИМ ДЭЭРЭЛХЭЛТИЙН ТУХАЙ СТАТИСТИК

Сүүлийн жилүүдэд үндэсний түвшинд хийгдсэн судалгаа, тайлангууд нь дэлхий нийт болон Азийн орнуудад цахим дээрэлхэлт нь ноцтой, өсөн нэмэгдэж буйг харуулж байна. Гэвч цар хүрээ болон мэдлэг, ойлголтын түвшин нь улс орон бүрт болон судалгааны аргачлалаас хамааран ялгаатай байна. Дэлхий дахинд 10–14% орчим хүүхэд, өсвөр үеийнхэн цахим дээрэлхэлтийн хохирогч болдог гэсэн судалгаа гарсан бөгөөд зарим судалгаанд тодорхойлолт болон судалгааны аргаас шалтгаалан энэ үзүүлэлт илүү өндөр хувьтай гарчээ (RISCS, 2025). Ази тивийн хэмжээнд цахим дээрэлхэлтийн дэлгэрсэн байдал болон илрэх хэлбэрүүд улс орнуудаар харилцан адилгүй байна. Энэ нь тухайн улсын соёл, нийгмийн орчин, цахим хэрэглээний онцлогоос ихээхэн хамаардаг. Жишээлбэл, Хятадад өргөн хүрээтэйгээр хийгдсэн судалгаагаар өсвөр насныхны 56.9% нь цахим дээрэлхэлтийн хохирогч, 34.9% нь дээрэлхэгч байсан гэж хариулжээ. Хамгийн нийтлэг хэлбэр нь хэн нэгнийг чат өрөөнөөс албаар хөөх явдал байсан. Судалгаагаар эрэгтэйчүүд цахим дээрэлхэлтийн аль аль талд (хохирогч болон үйлдэгч) байх магадлал өндөртэй байжээ. Хохирогчдын дийлэнх нь багш нараас илүүтэй найз нөхөд, анги хамт олондоо энэ талаар ярьдаг хандлага илэрсэн байна. Өмнөд Солонгос болон Тайваньд хийгдсэн судалгаанд цахим дээрэлхэлтийн хохирогч болох хувь нь Өмнөд Солонгост 5.4%, Тайваньд 20.4% байсан бөгөөд зарим тохиолдолд энэ нь уламжлалт дээрэлхэлтийн хувь хэмжээг давсан үзүүлэлт аж (Park, M. S.-A et al., 2021). Тайланд болон Японы 2,000 болон 100 сурагчийг хамруулсан харьцуулсан судалгаагаар Тайландад 59% нь сард дор хаяж нэг удаа цахим дээрэлхэлтэд өртсөн гэж хариулсан бол Японд энэ үзүүлэлт маш бага түвшинд байжээ (Ruangnapakuletal N. et al., 2019).

Филиппинд 395 оролцогчтой судалгаагаар 334 хүн цахим дээрэлхэлтийн хохирогч байсан бөгөөд ихэнх нь эмэгтэйчүүд байв (Costales J. et al., 2022).

Монгол Улсад Хүүхэд хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж батлагдсанаар цахим дээрэлхэлтээс хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн ч, судалгаанууд болон бодит тохиолдлууд нь хүүхдүүдийн цахим орчин дахь хамгаалуулах эрх зөрчигдсөөр байгааг харуулж байна. 2012 онд цахим гэмт хэргийн 17 тохиолдол бүртгэгдсэн бол 2018 онд 279 болж, зургаан жилийн дотор мэдэгдэхүйц өссөн байна. Улсын хэмжээнд эдгээр гэмт хэрэг 2012 оноос хойш 20 дахин өссөн бөгөөд ихэнх нь иргэдийг цахим орчноор дамжуулан залилан мэхэлсэн тохиолдлууд байжээ (Global Press Journal, 2023). Мөн “Хүүхдийн тусламжийн 108 утасны төв”-д цахим дарамт шахалтын талаар ирсэн дуудлагын тоо 2016 онд 85 байсан бол 2018 онд 229 болж өссөн нь бусад хүүхэд хамгааллын асуудлуудтай харьцуулахад хамгийн өндөр буюу 269%-ийн өсөлттэй гарсан байна. (Sustainable Development Initiative, 2021). 2023 онд 14–18 насны Монгол өсвөр үеийнхний дунд хийсэн эрдэм шинжилгээний судалгаагаар:

- 30% нь цэвэр цахим дээрэлхэлтийн хохирогч (өөрөө хохирсон, бусдыг дээрэлхээгүй),
- 19% нь хоёулангийн үүрэг гүйцэтгэсэн (өөрөө дээрэлхүүлж, бас бусдыг дээрэлхсэн),
- 6.7% нь цэвэр цахим дээрэлхэгч (өөрөө дээрэлхсэн ч хохирогч болоогүй) байсан гэж хариулжээ.

Эдгээр тохиолдлууд нь сүүлийн 12 сарын хугацаанд тогтмол эсвэл тодорхой давтамжтайгаар тохиолдсон байна (Badrakh A. et al., 2023).

# 6. ЦАХИМ ДЭЭРЭЛХЭЛТИЙН ТАЛААРХ СУДАЛГАА

Монгол Улсад одоогоор зөвхөн цахим дээрэлхэлтийн сэдвээр хийгдсэн бие даасан судалгаа байхгүй бөгөөд энэ асуудал нь зөвхөн хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой бусад судалгаанд хэсэгчлэн судлагдсан байдаг. Тиймээс энэхүү судалгаа нь энэхүү мэдлэгийн цоорхойг нөхөхийг зорьсон анхны оролдлого юм. Учир нь, цахим дээрэлхэлт нь уламжлалт дээрэлхэлтийн хэлбэрүүдээс онцлог, шинэ төрлийн сорилтуудыг бий болгосоор байна. Энэхүү судалгаа нь өсвөр насныхан, бага насны хүүхдүүд болон эцэг эхчүүдийн цахим дээрэлхэлтийн талаарх ойлголт, хандлага, тусламж хүсэх зан үйлийг гүнзгийрүүлэн судлах зорилготой байв. Сурагчдаас өгөгдөл цуглуулах замаар, өсвөр үеийнхэн цахим орчинд ямар гол сорилтуудтай тулгарч байгааг илрүүлж, тэдний сайн сайхан байдлыг дэмжих шийдлүүдийг боловсруулах үндэс суурийг тавьж байна.

## 6.1 Судалгааны арга зүй

### Зорилтот бүлэг

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн дагуу “хүүхэд” гэдэг нь 18 нас хүртэлх хүн гэж тодорхойлсон байдаг. Үүнийг баримтлан энэхүү асуулгыг хоёр насны бүлэгт зориулан боловсруулсан бөгөөд эдгээр нь: 9–12 нас болон 13–17 нас юм. Мөн хүүхэд ба өсвөр насныхны хөгжлийн ялгааг харгалзан үзэн эдгээр хоёр бүлэгт хуваарилсан юм. 9–12 насны хүүхдүүд нь оюун сэтгэлгээ, сэтгэл хөдлөлийн хөгжлийн анхан шатанд байдаг бол 13–17 насны өсвөр насныхан илүү нарийн төвөгтэй сэтгэлзүй, нийгмийн харилцаанд орж эхэлдэг. Ийм ялгаа нь тэдний цахим дээрэлхэлтийг хэрхэн хүлээж авч, хариу үйлдэл үзүүлэхэд нөлөөлөх нь гарцаагүй юм.

Мөн, эцэг эхийн үүрэг болон хүүхэдтэйгээ цахим орчинд хэрхэн харилцдаг талаарх ойлголтыг тодорхойлсон болно.

- **Нээлттэй харилцаа хамгийн чухал: Хүүхдийг цахим эрин үед зөв чиглүүлэх нь**

- Хүүхдийн цахим орчин дахь зан үйлийг хянахдаа шууд хориг тавихаас илүүтэйгээр нээлттэй, тогтмол харилцааг дэмжих нь илүү үр дүнтэй хандлага юм (Pew Research

Center, 2022). Эцэг эхчүүд хүүхдийнхээ цахим хэрэглээ, сонирхлыг байнга ярилцаж мэдэх замаар итгэлцлийг бий болгодог бөгөөд энэ нь хариуцлагатай, аюулгүй интернет ашиглалтыг зааж сургах суурь болдог.

- Мөн эцэг эхчүүд хүүхэддээ эрүүл, зөв хязгаар тогтоох тухай сургаж, тухайн үйл явцад идэвхтэй оролцох боломжтой. Үүнд, дэлгэцийн хэрэглээний цагийг тохируулах, хувийн нууц, аюулгүй байдалтай холбоотой тохиргоог зөвлөх, цахим орчны эрсдэлүүдийн талаар ярилцах зэрэг багтана.
- **Цахим ялгааг даван туулах нь: Эцэг эх, хүүхэдтэйгээ хамт суралцах**
- Зарим эцэг эхчүүдийн цахим ур чадвар хангалттай танил биш байж болохыг ойлгох нь чухал. Гэвч энэ нь хүүхэддээ аюулгүй орчинбүрдүүлэхэд заавалсаад тогторболно гэсэн үг биш. Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамт суралцаж, цахим орчны платформуудыг цуг судалж, туршиж үзэх боломжтой. Мөн эцэг эхчүүдийг цахим аюулгүй байдал, шинэ дижитал чиг хандлагын талаар мэдээлэлтэй байхад туслах олон төрлийн эх сурвалжууд бий.
- Нээлттэй харилцааг чухалчилж, хамтдаа суралцах замаар эцэг эхчүүд хүүхдийнхээ цахим амьдралын найдвартай хөтөч болж чадна. Ингэснээр илүү аюулгүй, хүртээмжтэй, баялаг цахим туршлага бий болох юм.

### Асуумж боловсруулалт

Монгол Улсад цахим дээрэлхэлт (кибер хүчирхийлэл) болон хүүхдийн цахим орчны аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдлыг цогцоор нь судлах зорилгоор энэхүү асуумжийг дараах зорилтуудын хүрээнд боловсруулсан болно:

- Насанд тохирсон асуултууд: Асуумжийг 9–12 болон 13–17 насны хүүхдийн хөгжлийн түвшин, цахим орчны дарамтыг

ойлгох чадварт тохируулан боловсруулсан. Энэ нь хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт нийцсэн, ойлгомжтой, хариулахад хялбар асуулт байхаар зорьсон.

- Эцэг эх, хүүхдийн харилцаа: Асуултуудаар эцэг эх, хүүхдийн цахим хэрэглээтэй холбоотой харилцааны онцлог, харилцан ойлголцол, харилцааны давтамжийг судалсан. Энэ нь эцэг эхийн анхаарал, оролцооны түвшинг тодорхойлох чухал үзүүлэлт болсон.
- Эцэг эхийн технологийн мэдлэг, чадвар: Судалгаагаар эцэг эхийн дижитал орчны мэдлэг, хэрэглээ, ялангуяа нийгмийн сүлжээ болон эцэг эхийн хяналтын хэрэгслүүдийн талаар хэр мэдээлэлтэй байгааг үнэлсэн. Энэ нь хүүхдээ цахим орчинд зөв удирдан чиглүүлэх чадвар болон сайжруулах шаардлагатай чадварыг тодорхойлоход тусалсан.
- Цахим дээрэлхэлт ба хүчирхийлэл: Асуултууд нь хүүхдэд тулгарсан цахим орчны дарамт, хүчирхийлэл, түүний давтамж, хэлбэрүүд (жишээлбэл: хоч нэрээр дуудсан, чатнаас хөөх, гаргах, заналхийлсэн гэх мэт) болон ямар цахим платформ дээр тохиолдсон талаар асуусан.

## Мэдээлэл цуглуулалт

Энэхүү судалгаанд Улаанбаатар хотын улсын болон хувийн 12 сургууль хамрагдсан бөгөөд сургуулиудын нэрийг хувь хүний нууцлалыг хамгаалах үүднээс зориудаар нууцалсан болно. Хэрэв судалгааны дэлгэрэнгүй мэдээлэл авах шаардлага гарвал судалгааны зохиогчидтой шууд холбогдохыг зөвлөж байна.

- \*\*\* дугаар Ерөнхий Боловсролын Сургууль, Баянзүрх дүүрэг, 13-р хороо
- \*\*\* дугаар төрийн ахлах сургууль, Баянзүрх дүүрэг, 13-р хороо
- \*\*\* нэрэмжит Сургууль № \*\*\*, Баянзүрх дүүрэг, 14-р хороо
- \*\*\* хувийн ахлах сургууль, Баянзүрх дүүрэг, 13-р хороо
- \*\*\*, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо
- \*\*\* хувийн ахлах сургууль, Сүхбаатар дүүрэг, 13-р хороо
- \*\*\* дугаар төрийн ахлах сургууль, Чингэлтэй

дүүрэг

- \*\*\* хувийн ахлах сургууль, Баянгол дүүрэг
- \*\*\* хувийн ахлах сургууль, Чингэлтэй дүүрэг, 40 мянгат
- \*\*\* хувийн ахлах сургууль, Баянзүрх дүүрэг, 13-р хороо
- \*\*\* олон Улсын сургууль, Сүхбаатар дүүрэг
- \*\*\* олон Улсын сургууль, Баянзүрх дүүрэг

Судалгаанд дээрх сургуулиудад суралцаж буй сурагчдын эцэг эх, жижиг дунд байгууллагын ажилтнууд мөн оролцсон.

*Улаанбаатар хотын хэмжээнд нийт 5,477 хүн оролцсон бөгөөд үүний 1,620 нь эцэг эх, 3,857 нь сурагч тус тус хамрагдсан болно. Энэхүү судалгаа нь цахим дээрэлхэлт, дарамт, хүчирхийллийн талаар учраас судалгаа авсан сургуулиудын нэрийг ил задлахгүй байх бодлогыг баримталж байна.*

## 6.2 Ёс зүйн стандарт

Энэхүү судалгаа нь хүүхдүүдийн дунд цахим дээрэлхэлт тохиолдож байгаа эсэх, мөн эцэг эхчүүд үүнийг хэр мэдэж байгаа болон цахим аюулгүй байдлын талаарх ойлголттой эсэхийг тодруулахад чиглэсэн юм. Судалгааг НҮБ-ын Хүүхдийн Сангийн судалгаа, үнэлгээ, мэдээлэл цуглуулалт, дүн шинжилгээний ёс зүйн стандартыг баримтлан явуулсан болно (Turku, KiVa Program & University of, 2006). Сурагчид болон эцэг эхчүүдэд зориулсан асуумжуудыг хувь хүнийг шууд таних боломжгүй байдлаар боловсруулсан бөгөөд өөрийн зөвшөөрлөөр оролцох, хүссэн асуултаа алгасах эрхтэй байхаар зохион байгуулагдсан. Хэрэв асуумж дунд тухайн оролцогч сэтгэлзүйн дарамтад орж болзошгүй нөхцөл байдал үүсэх тохиолдолд тусламжийн утасны дугаар болон бусад холбогдох байгууллагын мэдээллийг асуумжид тодорхой заасан. Үүнээс гадна, ёс зүйн анхаарах асуудлууд болон мэдээллийг нууцлах журмыг багийн зүгээс урьдчилан тайлбарлаж өгсөн. Цуглуулсан мэдээлэл нь зөвхөн нэгдсэн, нэргүй байдлаар ашиглагдах бөгөөд тодорхой хугацааны дараа устгагдана.

Цахим судалгаа зарим талаараа хязгаарлагдмал байдгийг мөн анхаарах шаардлагатай. Гар бичвэр таних асуудал ихэнх цахим судалгаанд хамааралгүй ч, энэ сэдэв нь хүүхдүүдэд эмзэг тусаж болзошгүй тул бусад арга замуудыг анхаарах нь зүйтэй. Судалгаанд хамтран ажилласан “Info Sec Plus”

гэх цахим аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэгч компани нь ил тод байдлыг хангаж, судалгааны явцад хүүхдүүдийн асуусан бүх асуултад үнэн зөв, ойлгомжтой хариулт өгсөн. Судалгааны явцад давуу байдал үүсэх эрсдэлийг урьдчилан тооцож, асуумжийг нас, сэтгэхүйн онцлогт тохируулан туршиж, нээлттэй асуулт асуух замаар боловсруулсан. Судалгааг удирдан явуулсан ажилтнууд нь сэтгэл зүйн дарамт үүсгэхгүй, төвийг сахисан байдлаар харилцах тусгай сургалт авсан. Цаашид судалгааны ёс зүйг улам сайжруулах зорилгоор байнгын үнэлгээ, дүгнэлт, туршлага солилцох үйл ажиллагаа үргэлжлүүлэн хийгдэх болно.

### 6.3 Үр дүн

Судалгааны үр дүн нь Монголын хүүхэд, залуучууд, гэр бүлийн хүрээнд цахим дээрэлхэлтийн асуудал нарийн төвөгтэй бөгөөд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна. Улаанбаатар хотын хэд хэдэн улсын болон хувийн сургуулиудын сурагчид, эцэг эхчүүдээс асуулга авч, тус асуудлын тухай өргөн цар хүрээтэй, цогц мэдээллийг бүрдүүлэхийг зорьсон. Голлох үр дүнгүүдээс дурдвал:

- **Эцэг эхийн мэдлэг ба оролцоо:** Судалгаагаар олон эцэг эх хүүхдүүдийнхээ цахим хэрэглээг хянахыг оролддог ч мэдлэг, чадварын дутагдалтай байгааг харуулж байна. Эцэг эхийн талаас 50 гаруй хувь нь ямар нэг байдлаар хяналт тавьдаг гэж мэдүүлсэн боловч үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг нь илэрсэн. Тухайлбал, эцэг эхчүүдийн 37.2% нь Facebook хэрэглэх насны доод хязгаарыг мэддэггүй, мөн олонх нь хүүхдүүд нь цахим дээрэлхэлтэд өртсөн эсэхэд тодорхой хариулж чадаагүй нь ерөнхий мэдлэг, ойлголтын дутагдлыг илэрхийлж байна.
- **Хүүхдийн цахим хэрэглээ ба эрсдэл:** 9–12 насны хүүхдүүдийн гуравны хоёр нь өдөр тутамд интернет ашигладаг ба тэдний гол үйлдлүүд нь чат бичих, хичээлээ хийх, тоглоом тоглох юм. Энэ нь тэднийг зохисгүй үг хэллэг, хортой харилцаа зэрэг эрсдэлд илүү өртөмтгий болгодог. Жишээ нь, 9–12 насны хүүхдүүдийн талаас илүү хувь нь цахим тоглоомын орчинд зохисгүй хэллэгтэй таарч байснаа дурьдсан ба 90% нь насны хязгаарлалттай байсан ч Facebook ашиглаж байсан гэжээ.

- **Цахим дээрэлхэлтийн тархалт ба шинж чанар:** Цахим дээрэлхэлт өргөн тархсан бөгөөд далд байдлаар илэрдэг. 9–12 насны хүүхдүүдийн гуравны нэг, харин 13–17 насны өсвөр үеийнхний талаас илүү хувь нь цахим дээрэлхэлт, доромжлолд өртөж байсан гэв. Үйлдлүүдийн дийлэнх нь доромжлох, нэр хүндэд халдах, мөн хамгийн ноцтой нь бэлгийн шинжтэй дарамт байв. Хүүхдүүд олон хуурамч аккаунт хэрэглэдэг бөгөөд үүнийгээ нууцлалын үүднээс гэж тайлбарлагдаж байсан ч энэ нь буруу зуршил, үйлдлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй.
- **Хүйсийн ялгаа:** Цахим дээрэлхэлт нь эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдэд адилхан нөлөөлдөг. 9–12 насны хүүхдүүдийн аль аль нь цахим дээрэлхэлтийн талаар тодорхой ойлголттой байсан ч хөвгүүдийн мэдлэг арай илүү байжээ. Гэвч эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль алинд нь цахим дээрэлхэлтийн талаар огт сонсоогүй тохиолдол байсаар байгаа нь боловсрол олгох, энэ асуудлын тухай мэдлэг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна. Мөн хөвгүүд, охидын зүгээс дарамт мэдэрсэн тохиолдолд хэнд мэдээлэх сонголт ялгаатай – гэр бүлдээ хэлэх нь хамгийн нийтлэг сонголт байсан ч охид найздаа хэлэх, эсвэл хэнд ч хэлэхгүй байх магадлал илүү өндөр байв.
- **Сэтгэл зүйн нөлөөлөл:** Цахим дээрэлхэлт нь Монгол хүүхдүүдийн сэтгэл зүйд хүчтэй нөлөө үзүүлж байна. Хэт түгшүүртэй болох, сэтгэл гутралд орох, хичээлдээ муудах, ноцтой тохиолдолд амиа хорлох бодол төрөх зэрэг шинж тэмдэг илэрч байгаа нь энэ асуудал ноцтой хэмжээнд хүрснийг сануулж байна.
- **Бусдад мэдэгдэх ба тусламж эрэхэд тулгарч буй бэрхшээлүүд:** Өсвөр үеийнхний 2/3 нь цахим дээрэлхэлтийн талаар насанд хүрэгчидтэй хуваалцадаггүй гэсэн нь тэд насанд хүрэгчдэд итгэхгүй эсвэл мэдээллэх механизм үр дүнгүй гэж боддогийг харуулж байна. Мөн сурагчдын талаас илүү хувь нь сургууль дээрээ цахим дээрэлхэлтийн талаар ямар нэг боловсрол авч байгаагүй гэсэн нь урьдчилан сэргийлэх мэдлэг, дэмжлэгийн систем дутагдаж байгааг илтгэнэ.
- **Эцэг эхийн хяналт ба харилцааны хүндрэлүүд:** Эцэг эхчүүд хүүхдийн цахим хэрэглээг хянахыг хүсдэг ч хэрэгжүүлэх арга зам нь тодорхой бус, технологийн мэдлэг

дутмаг, хүүхдүүдтэйгээ нээлттэй харилцахад хүндрэлтэй байдаг нь тодорхой байна. Тиймээс эцэг эхчүүдийг дэмжих тусгай сургалт, нөөц мэдээлэл шаардлагатай байна.

- **Цахим хэрэглээ ба дээрэлхэлтийн хамаарал:** Интернетийн хэрэглээ их байх нь цахим дээрэлхэлтэд өртөх эрсдэлийг нэмэгдүүлэх, харилцаа холбоо сул буюу мэдэгдэхүйц ихэсгэхгүй гэдэг үр дүн гарсан.
- **Нас ба мэдээлэх зан төлөвийн шинжилгээ, харилцаа хамаарал:** Өсвөр насны хүүхдүүд илүү хүчтэй сөрөг сэтгэл хөдлөл мэдрэх, тусламж эрэх нь илүү түгээмэл байна. 9–12 насны хүүхдүүдийн хувьд цахим дээрэлхэлтэд өртсөнөөр сөрөг сэтгэл хөдлөл мэдрэх нь маш сул байсан бол 13–17 насныхны хувьд цахим дээрэлхэлт ба сөрөг сэтгэл хөдлөл мэдрэх нь дунд зэрэг хамааралтай байна. Энэ нь 13-аас дээш насны өсвөр үеийн хүүхдүүд цахим дээрэлхэлтэд өртсөн тохиолдолд хүчтэй сөрөг сэтгэл хөдлөл мэдрэх магадлал өндөр, харин бага насныханд энэ хамаарал маш сул байгааг харуулж байна. Мөн мэдээлэх зан төлөв ба цахим дээрэлхэлтэд өртсөн байдал хоорондын хамаарал 9–12 насныхны хувьд сул сөрөг хамааралтай байсан нь тэд ийм туршлагаа бусдад мэдэгдэх магадлал бага байгааг илтгэнэ. Харин 13–17 насныхны хувьд сул эерэг хамааралтай байсан нь тэд цахим дээрэлхэлтэд өртсөн бол мэдээлэх магадлал арай илүү байгааг харуулж байна. Эдгээр үр дүн нь хүүхдүүд цахим дээрэлхэлтэд өртсөн үедээ тусламж эрэх эсэхэд насны ялгаа нөлөөлдөг болохыг харуулж байна.
- **Сургууль болон сургалтын нөлөө:** 13–17 насныханд цахим дээрэлхэлттэй тэмцэх сургууль дээр зохион байгуулагддаг сургалт, мэдээлэл нь тэдний өөрийгөө хамгаалах хангалттай арга хэрэгсэл болж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, сургууль дээр мэдлэг олголоо ч хүүхдүүдийн хариу үйлдэлд хүчтэй нөлөө үзүүлдэггүй.


Эцэг эхчүүдийн мэдлэг, сургуулийн боловсрол, дэмжлэгийн механизмуудад ноцтой дутагдал байгаа нь хүүхдүүдийг цахим дээрэлхэлтээс үр дүнтэй урьдчилан сэргийлэхэд саад учруулж байна. Судалгааны үр дүн нь эцэг эхчүүд болон сурагчдын дижитал боловсролыг сайжруулах, сэтгэцийн эрүүл мэндийн хүртээмжтэй нөөц бий болгох, сургууль болон олон нийтийн дэмжлэгийн

тогтолцоог бэхжүүлэх зэрэг цогц стратеги шаардлагатайг онцлон харуулж байна. Ингэснээр Монгол улсын бүх хүүхэд, өсвөр насныханд илүү аюулгүй, дэмжлэгтэй дижитал орчин бүрдүүлэх боломжтой болно.

Оролцогч бүлэг тус бүрийн нарийвчилсан үр дүнг доор танилцуулж байна:

## Эцэг, эх

Судалгаанд нийт 1,620 эцэг эх оролцсон. Ихэнх нь (57.4%) 35-44 насны хүмүүс байсан бол 28.8% нь 45-54 насныхан, 11.3% нь 25-34 насныхан байв. Үлдсэн эцэг эхчүүд 55-аас дээш настай байжээ.



Зураг 1: Эцэг эхийн оролцоо


## Эцэг эхчүүдийн асуулгын гол үр дүнг дараах байдлаар дүгнэж болно:

Сонирхолтой нь, Facebook ашиглах хамгийн доод насны хязгаарын талаар асуухад эцэг эхчүүдийн 37.2% нь буруу хариулж, 8 эсвэл 10 нас гэж үзсэн байна. Гэвч бодит байдал дээр энэ нас 13 байдаг. Энэ нь хүүхдийн цахим аюулгүй байдлын талаарх мэдлэгийн дутагдал байгааг харуулж байна.




Зураг 2: Насны шалгуурын тухай ойлголт

Эцэг эхчүүдийн талаас илүү хувь (51.8%) нь хүүхдийнхээ интернет хэрэглээг хянадаг гэж хариулсан бол 39%-д нь хянах хүсэл байгаа ч тодорхой бэрхшээлүүдтэй тулгардаг гэжээ.



Зураг 3: Интернет хэрэглээний хяналт

Хүүхдүүд хэт их электрон төхөөрөмж ашиглахад гардаг шинж тэмдгүүдийн талаар асуухад, эцэг эхчүүдийн 31.8% нь нойргүйдлийг гол асуудал гэж үзжээ. Үүний дараа 29.5% нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлж, хүүхдүүд хичээлдээ муудах эрсдэлтэй гэж хариулсан байна. Бусад хариултуудад сэтгэл гутрал, хооллолтын эмгэг, түрэмгий зан авир зэрэг асуудлууд багтжээ.



Зураг 4: Электрон төхөөрөмжний нөлөө

Хүүхдээ цахим дарамтад өртөж байсан эсэх талаар асуухад, эцэг эхчүүдийн 61.3% нь “Үгүй” гэж хариулсан. Гэвч 34.5% нь “Мэдэхгүй” гэж хариулсан нь цахим дарамтын шинж тэмдгүүдийг мэдэхгүй байх, эсвэл хүүхдийнхээ цахим үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэлгүй байгааг илтгэж байна.



Зураг 5: Эцэг эхчүүдийн ойлголт

**Эцэг эхчүүдийн хяналт тавихад тулгардаг бэрхшээлүүд:** Эцэг эхчүүдийн бараг тал хувь (48.2%) нь хүүхдийнхээ интернет хэрэглээг хянахыг хүсдэг ч үр дүнтэй арга замыг олоход хүндрэлтэй байдаг гэж хариулсан. Энэ нь энэ чиглэлд илүү сайн нөөц, мэдлэг шаардлагатай байгааг харуулж байна.



Зураг 6: Эцэг эхийн хяналт тавихад бэрхшээлүүд

Цахим аюулгүй байдлын мэдлэгийн хомсдол: Эцэг эхчүүдийн дунд цахим аюулгүй байдлын талаар мэдлэгийн томоохон зөрүү байгааг харуулж байна. Нийт эцэг эхчүүдийн 35.8% нь Facebook, Instagram зэрэг платформуудыг ашиглах доод насны хязгаар 13 гэдгийг мэддэггүй байна.



Зураг 7: Мэдлэгийн хомсдол

*Хүүхдүүдийн тал хувь нь цахим дарамтад өртсөн тухайгаа эцэг эхдээ хэлээгүй гэсэн дүгнэлт нь эцэг эх, хүүхдийн хооронд харилцааны зөрчилдөөн эсвэл мэдээлэх механизмд итгэхгүй байгааг илтгэж байна. Энэ нь эцэг эх, хүүхдүүдийн хооронд цахим аюулгүй байдлын талаар нээлттэй харилцаа холбоо тогтоох шаардлагатай байгааг онцолж байна.*

**Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ цахим дарамтыг мэддэггүй байж болох шалтгаанууд нь:**

- Харилцааны дутагдал
- Үр дүнгүй харилцааны арга барил
- Цахим дарамтын шинж тэмдэг, онцлогийг мэдэхгүй байх
- Цахим аюулгүй байдал, технологийн талаар мэдлэггүй байх


## 9-12 насны бүлэг

Судалгаанд 1251 хүүхэд хамрагдсан ба үүнээс 53.7% нь эмэгтэй бол 46.3% нь эрэгтэй хүүхдүүд байсан.



Зураг 8: Хүйсийн харьцуулалт

Сонирхолтой нь, судалгаагаар 3 хүүхэд тутмын 2 нь (ойролцоогоор 66.7%) өдөр бүр интернэт ашигладаг болох нь тогтоогджээ. Энэ өндөр хэрэглээ нь ихэвчлэн хүүхдүүд чатлах, хичээл хийх эсвэл тоглоом тоглох зэрэг үйл ажиллагаанд интернэт ашигладагтай холбоотой байж болох юм.



Зураг 9: Бүдүүлэг үг хэллэг ашиглах

Мөн судалгаагаар хүүхдүүдийн 53.6% нь онлайн тоглоом тоглох үедээ бүдүүлэг үг хэллэгтэй таарч байсан гэж хариулжээ.




Зураг 10: Фэйсбүүк ашиглалт

Түүнчлэн нэг ноцтой асуудал гарч ирсэн нь судалгаанд оролцсон хүүхдүүдийн 90% нь насны шаардлага хангахгүй атлаа Facebook ашигладаг гэж хариулсан байна.

Олон хүүхэд цахим орчинд тохиромжгүй үг хэллэгтэй таарж бөгөөд 53.6% нь тоглоом тоглох явцдаа муу үгсийг сурч, ашигладаг гэж хариулжээ. Энэ нь цахим орчин хүүхдүүдэд хэрхэн нөлөөлж болохыг харуулж байна.

Тайланд дурдсанаар хүүхдүүдийн ихээхэн хувь (ойролцоогоор 50%) цахим дарамтад өртсөн нь энэ асуудлын ноцтой байдлыг баталж байна.

Тайланд интернэт ашиглалтын тодорхой хувийг хичээл хийхэд зориулан ашигласан тухай дурдаагүй ч Монгол Улсын боловсролын системд нэгдсэн боловсролын платформ чухал болохыг онцолж байна. Ингэснээр сургалтын материалд хандах боломжийг сайжруулж, цахим сургалтын туршлагыг дээшлүүлэх боломжтой юм.



Зураг 11: Хуурамч эсвэл нэмэлт өөр аккаунт

Судалгаагаар хүүхдүүдийн электрон төхөөрөмжийн хэт их хэрэглээ нь нойргүйдэл, хоолны дуршил буурах, сурлагын чанар муудах зэрэг шинж тэмдгүүдтэй холбоотой болохыг тогтоожээ.

Нэгэн санаа зовоосон тоо баримт гарч ирсэн нь хүүхдүүдийн гуравны нэг нь цахим дарамтад өртсөн гэж мэдээлжээ.

## 13-17 насны бүлэг

Судалгаанд 13-17 насны 2606 сурагч оролцсон байна.

### Интернэт хэрэглээ:

**Идэвхтэй хэрэглээ:** Өсвөр насныхны талаас илүү хувь буюу 53.6% нь өдөрт 4-өөс дээш цагийг интернэтэд зарцуулдаг нь цахим орчинд идэвхтэй оролцдогийг харуулж байна.



Зураг 12: Өсвөр үеийнхний дундах интернэтийн хэрэглээ

Эерэг хэрэглээ: Чатлах, хичээл хийх нь интернэт ашиглах гол шалтгаан болж байгаа нь өсвөр насныхан харилцаа холбоо, боловсролдоо ашиглаж буйг илтгэнэ.

## Нийгмийн сүлжээ ба цахим дарамт:

*Олон аккаунт: Нэгэн анхаарал татсан хандлага нь өсвөр насныхны гуравны нэг нь Facebook дээр олон аккаунттай байдаг явдал юм. Энэ нь нууцлалын асуудал эсвэл онлайн хувийн болон нийтийн дүр төрхөө тусгаарлах хүсэлтэй холбоотой байж болзошгүй.*

### Цахим дээрэлхэлтийн өргөн тархалт:

Өсвөр насныхны тэн хагас нь цахим дарамт, доромжлолд өртсөн гэх тоо баримт нь ноцтой асуудлыг илтгэж байна.

**Тодорхойгүй нөлөө:** Хүүхдүүдийн 50% цахим дээрэлхэлт тэдэнд хэрхэн нөлөөлснийг нь тодорхойлж мэдэхгүй байгаа нь сэтгэлзүйдээ хэрхэн нөлөөлж буйг ойлгоход нь дэмжлэг, зөвлөгөө шаардлагатай байж болзошгүйг харуулж байна.



Зураг 13: Тодорхойгүй нөлөө

*Сэтгэцийн эрүүл мэндийн асуудал: Сэтгэл гутралд орсон 200 өсвөр насны хүүхэд тутмын нэг нь амиа хорлох тухай бодож байсан гэх мэдээлэл нь цахим дарамт сэтгэцийн эрүүл мэндэд хэр ноцтой нөлөө үзүүлж болохыг харуулж байна.*



Зураг 14: Цахим дээрэлхэлтийн сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлж буй нөлөө

### Мэдээлэхгүй өнгөрөх ба мэдлэггүй байдал:

Нэн чухал асуудал бол өсвөр насныхны 3 хүүхэд тутмын 2 нь цахим дээрэлхэлтийн талаар бусдад мэдээлдэггүй явдал юм. Энэ нь мэдээлэх механизм хүүхдүүдийн төлөө ажиллахгүй байгааг илтгэж байна. Нэмж дурдахад, өсвөр насныхны 53.4% нь сургууль нь цахим дарамтын талаар мэдээлэл өгөөгүй гэж хариулсан нь сургуулийн түвшинд энэ талаарх ойлголт дутмаг байгааг харуулж байна.

*Мэдээллээс харахад өсвөр насныхны 3 хүүхэд тутмын 2 нь цахим дээрэлхэлтийн талаар мэдээлдэггүй бөгөөд ихэвчлэн мэдээлэх нь ямар ч хэрэггүй эсвэл ичмээр санагддаг учраас мэдээлдэггүй аж.*

Хүүхдүүдийн гуравны нэг нь хоёр буюу түүнээс дээш Facebook хаягтай байдаг бөгөөд нэрээ нууцлах, нууцаа хадгалах хүсэл нь гол шалтгаан болдог. Гэсэн хэдий ч энэ нэрээ нууцлах байдал нь цахим дээрэлхэлт зэрэг сөрөг зорилгоор ашиглагдах боломжтой юм.

*Судалгаагаар хүүхдүүдийн 51.3% нь цахим дээрэлхэлтэд өртсөн байна. Цахим дээрэлхэлтийн хамгийн түгээмэл хэлбэрүүд нь доромжлол, гутаан доромжлох явдал байсан бол 5% нь бэлгийн дарамтад өртсөн гэж харуулжээ.*

Цахим дээрэлхэлт маш түгээмэл тохиолддог бөгөөд (өмнөх мэдээллээр 51.3% нь ийм туршлагатай) хэдий ч хүүхдүүдийн тэн хагас нь энэ талаар ярихаас зайлсхийдэг. **Энэ нь насанд хүрэгчдэд итгэх итгэл дутмаг эсвэл мэдээлэх нь үр дүнгүй гэсэн итгэл үнэмшилтэй холбоотой байж болзошгүй юм.**

- 2606 хүүхдээс 10 хүүхэд нь цахим дээрэлхэлтийн улмаас сэтгэл гутралд орж, амиа хорлох бодол төрсөн нь санаа зовоосон асуудал юм. Энэ нь цахим дээрэлхэлтэд өртсөн өсвөр насныханд зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг яаралтай хүргэх шаардлагатайг харуулж байна.
- **Мэдээллээс харахад судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн талаас илүү хувь нь сургуульдаа цахим дээрэлхэлтийн талаар боловсрол авч байгаагүй байна.** Энэхүү мэдлэгийн дутагдал нь тэднийг цахим дээрэлхэлтийг таних, хариу арга хэмжээ авах, мэдээлэхэд бэлэн бус байдалд оруулж байна.

**Интернэт ашиглалтын хугацаа нь цахим дээрэлхэлтийн туршлагатай хамааралтай болохыг манай шинжилгээ дараах байдлаар харуулж байна:**

- Өсвөр насныхны интернэтэд зарцуулдаг хугацаа болон цахим дээрэлхэлтэд өртөх магадлалын хооронд статистикийн хувьд ач холбогдолтой боловч сул хамаарал байна. Интернэтэд илүү олон цаг зарцуулдаг, ялангуяа 4-6 цаг болон 6-аас дээш цаг зарцуулдаг өсвөр насныхан интернэтэд бага цаг зарцуулдаг хүүхдүүдтэй харьцуулахад цахим дээрэлхэлтэд өртөх магадлал өндөр байгааг мэдээлсэн.
- Өдөр тутмын интернэт ашиглалтын цаг болон насанд хүрэгчдийн контентод өртөх хооронд дунд зэргийн хамаарал ажиглагдсан. Ялангуяа 4-6 цаг болон 6-аас дээш цаг интернэт ашигладаг өсвөр насныхан насанд хүрэгчдийн контентод илүү өндөр хувиар өртдөг болохыг мэдээлсэн. Энэхүү хамаарал нь шинжилгээнд тодорхойлсон хамгийн хүчтэй хамаарлуудын нэг бөгөөд интернэт хэрэглээ ихтэй хүүхдүүдэд тохиромжтой хяналт тавих, контентыг шүүх шаардлагатайг онцолж байна.

---

*Монголын ирээдүй болсон хүүхдүүд цахим дээрэлхэлтэд өртсөн үед тусламж авах төвтэй байх ёстой.*

*Түмнээгийн Тэлмүүн – Монгол Улсын Их Сургуулийн багш*

---

Ерөнхийдөө, эдгээр үр дүн нь өсвөр насныхан интернэт орчныг идэвхтэй хэрэглэж байгаа бөгөөд цахим дээрэлхэлт болон дэмжлэгийн тогтолцооны хомсдол байгааг илтгэж байна. Энэхүү судалгаа нь Монгол улсын өсвөр насныханд зориулсан хариуцлагатай интернэт хэрэглээг дэмжих, цахим дээрэлхэлтийг үр дүнтэй шийдвэрлэх, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

# 7. ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА

Цахим дээрэлхэлтийг шийдвэрлэх олон улсын шилдэг туршлагауд нь боловсрол, бодлого, дэмжлэгийн тогтолцоог хослуулсан цогц, олон талын оролцоотой арга барилыг онцолдог. Гол стратегиуд нь:

- **Нийт сургуулийн бодлого ба мэдлэг олгох кампанит ажил:** Сургуулиуд цахим дээрэлхэлтийн эсрэг тодорхой бодлого хэрэгжүүлж, дижитал иргэн болох, энэрэнгүй сэтгэлгээний сургалтыг хичээлийн хөтөлбөртөө тусган, сурагчид, багш нар, эцэг эхчүүдийн хооронд нээлттэй харилцаа бий болгохыг уриалдаг. Жишээлбэл, Финландын KiVa хөтөлбөр (Turku, KiVa хөтөлбөр & Их сургууль, 2006) багш нарын сургалт, сурагчдын хичээл, цахим сургалтын орчин зэргийг хамардаг. Энэ хөтөлбөр нь цахим дээрэлхэлтийн хохирогч болох тохиолдлыг дунд зэргийн хэмжээнд бууруулж, сургуулийн орчныг сайжруулсан гэж үздэг. Сингапур улс нийт сургуулиудад зориулсан Кибер сайн сайхан байдлын хөтөлбөрийг (Боловсролын яам, 2014–2025) нэвтрүүлж, дижитал хариуцлага, аюулгүй цахим зан үйлийг чухалчилж байна.
- **Эцэг эхийн оролцоо:** Эрсдлээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх арга нь эцэг эхчүүдийн технологи хэрэглэх ур чадварыг нэмэгдүүлэх, нээлттэй яриа өрнүүлэх, цахим орчинд хүндэтгэлтэй харьцаж, хүүхдэдээ үлгэр дууриал үзүүлэхэд оролцуулах юм. Хязгаарлалт тавихаас илүүтэйгээр залуучуудтай хамтран ажиллаж, цахим дээрэлхэлтээс сэргийлэх хөтөлбөрүүд нь илүү үр дүнтэй амжилттай болсон жишээ бий. Ирландад “It Takes a Village” хөтөлбөр (CLG, Greystones Town Team, Ireland, 2023) нь найман бага сургуулийн эцэг эхчүүдийг хүүхдүүддээ ухаалаг утас авахыг хойшлуулах амлалт өгөхөд уриалсан. Энэ санаачилга нь сургуулийн түвшинд хэрэгжсэн дижитал мэдлэг олгох хөтөлбөрүүдтэй хослон сурагчдын дунд түгшүүрийг бууруулж, цахим аюулгүй байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулсан. Малайзад сургуулиуд болон засгийн газрын агентлагууд эцэг эхчүүдийг семинар, хамтарсан хөтөлбөрүүдээр дамжуулан оролцуулж, гэртээ технологийн хэрэглээний зааварчилгаа өгөх,

нээлттэй харилцааны ач холбогдлыг онцолж байна. Малайзын Боловсролын Цэнхэр Хэвлэл 2013-2025 (Боловсролын яам, Малайз, 2013-25) нь эцэг эхийн үүрэг, эцэг эх, багш, олон нийтийн идэвхтэй хамтын ажиллагааг чухалчилж, сурагчдын суралцах үйл явцыг дэмжих “хамтын хариуцлага”-тай байхыг уриалсан.

- **Нийгмийн ур чадвар ба дижитал боловсролын сургалт:** Бусдыг ойлгох, хүндэтгэх, асуудал шийдвэрлэх чадварыг заах нь цахим дээрэлхэлтийн тохиолдлыг бууруулахад тустай. Дижитал боловсролын хөтөлбөрүүд нь хүүхэд, өсвөр насныханд цахим орчинд аюулгүй, хариуцлагатай байх чадварыг олгодог. Германд хэрэгждэг “Surf-fair” сургалтын хөтөлбөр (Espelage D.L et al., 2016) нь 11-12 насныханд зориулсан цахим дээрэлхэлтийн тодорхойлолт, даван туулах арга зам, хууль эрх зүйн талаарх мэдлэгийг олгодог. Энэхүү хөтөлбөр нь цахим дээрэлхэлтийн хохирогч болох тохиолдлыг мэдэгдэхүйц бууруулсан. Вьетнамын “Найрсаг сургуулиуд ба идэвхтэй сурагчид” хөтөлбөр (Боловсрол, сургалтын яам, Вьетнам, 2009) нь амьдралын ур чадвар болон үнэт зүйлсийн боловсролыг сургалтын хөтөлбөрт нэгтгэн, сурагчдыг хүчирхийлэл болон цахим дээрэлхэлтийг даван туулах чадвартай болгодог.
- **Мэдээлэх систем ба дэмжлэгийн механизм:** Улсын хэмжээнд тусламжийн утас ажиллуулах, сургуульд мэдээлэх систем бий болгох, нууцлалтай дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэх нь хохирогчдод цаг алдалгүй тусламж авах боломжийг олгодог. Испанийн Наварра муж дахь “Laguntza” хөтөлбөр (EPRS, 2025) нь багш, сурагч, гэр бүлд зориулсан тусгай сургалт, мэдээлэх зориулалттай вэбсайт зэрэг хэрэгслийг санал болгодог. Энэ нь сургуулиудад илүү шуурхай, үр дүнтэй арга хэмжээ авах боломжийг бүрдүүлсэн. Тайланд улс “Stop Bullying Chat Line” хэмээх тусламжийн утас ажиллуулж, хүүхдийн сэтгэл зүйчидтэй зөвлөгөө авах, дээрэлхэлттэй холбоотой мэдээлэл авах боломжийг олгодог. (Тайланд, The Nation, 2018)

- **Технологийн компаниудтай хамтран ажиллах:** Засгийн газар болон төрийн бус байгууллагууд нийгмийн сүлжээний платформуудтай хамтран ажиллаж, контентын хяналт, мэдээлэх хэрэгслүүд болон нууцлалын тохиргоог сайжруулснаар залуу хэрэглэгчдэд илүү аюулгүй цахим орчин бүрдүүлэхийг зорьдог. Нидерландын TABASCO төсөл (Union, European, 2023) нь сурагчид болон нөлөөлөгчдийг оролцуулан цахим дээрэлхэлтийн эсрэг мессежүүдийг хамтран түгээж, эдгээрийг нөлөөлөгчид нийгмийн сүлжээгээр түгээх замаар эерэг зан үйлийг дэмжихэд чиглэсэн. Энэхүү хамтын ажиллагаа нь олон нийтийн мэдлэгийг дээшлүүлж, сурагчдыг цахим дээрэлхэлтийн эсрэг арга хэмжээ авахад урамшуулсан. Өмнөд Солонгост засгийн газрын агентлагууд болон технологийн компаниудын хамтын ажиллагаа нь цахим орчны аюулгүй байдлыг сайжруулахад хүргэсэн.
- **Хууль, бодлогын хүрээ:** Олон улс цахим дээрэлхэлтийг тусгайлан зохицуулах хууль тогтоомж баталж, эсвэл шинэчилсэн бөгөөд энэ нь дээрэлхэгчдэд тодорхой хариуцлага тооцох, хохирогчдыг хамгаалах үндсийг бүрдүүлдэг.

Бельгийн Фландрын бүс нутагт сургуулиудад заавал хэрэгжүүлэх ёстой дээрэлхэлтийн эсрэг бодлого боловсруулж, Фламандын засгийн газар болон “Vlaams Netwerk Kies Kleur tegen Pesten” байгууллага дэмжиж ажилладаг. Сургууль, эцэг эх, залуучуудын холбоонд зориулсан хэрэгслүүдийг бий болгосноор урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээ авах чадавх сайжирч, мэдээлэх тохиолдол нэмэгдэж, хэрэг гаралт буурсан нь нотлогдсон. (EPRS, 2025) Филиппин болон Сингапур улс цахим дээрэлхэлтийн эсрэг тусгай хууль, журам баталж, гэмт хэргийн тодорхойлолт болон шийтгэлийг тодорхой зааж өгсөн.

Эдгээр шилдэг туршлагууд нь сургууль, гэр бүл, засгийн газар болон технологийн байгууллагуудын хамтын ажиллагааны ач холбогдлыг онцлон харуулж байна. Хүүхэд, залуучуудын аюулгүй цахим орчныг бүрдүүлэхийн тулд боловсрол, гэр бүлийн оролцоо, дижитал бичиг үсгийн чадвар, мэдээлэх тогтолцоо, төр-хувийн хэвшлийн түншлэл болон хууль эрх зүйн хүрээ зэрэг олон талт, тухайн нөхцөлд тохирсон арга хэмжээг хослуулан хэрэгжүүлэх шаардлагатай юм.

# 8. ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

## Дүгнэлт

Монголын хүүхэд, өсвөр үеийнхний дундах цахим дээрэлхэлтийн талаарх энэхүү судалгааны үр дүн нь уг асуудлыг яаралтай шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байгааг тодорхой харуулж байна. Судалгаанаас харахад 9-12 насны хүүхдүүдийн дунд цахим дээрэлхэлтэд өртөх тохиолдол их байгаа бөгөөд 13-17 насны өсвөр үеийнхний хувьд энэ үзүүлэлт улам өндөр буюу 51.3 хувьд хүрчээ. Хүүхдүүд, өсвөр үеийнхэн цахим орчинд доромжлол, дарамт, бүр бэлгийн дарамт хүртэл амсаж байгаа нь тун ноцтой асуудал юм.

## Цахим дээрэлхэлтийн талаарх гол баримтууд:

- 9-12 насны хүүхдүүдийн гуравны нэг нь цахим дарамтад өртсөн. 13-17 насныхны 51.3 хувь нь цахим дарамтад өртсөн.
- Судалгаанд оролцсон хүүхдүүдийн 53.6 хувь нь цахим орчинд зохисгүй үг хэллэг сурч, хэрэглэдэг.
- Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 90 хувь нь Facebook ашигладаг боловч насны доод шаардлага хангаагүй.
- Цахим дарамтад өртсөн хүүхдүүдийн тал хувь нь энэ талаар мэдээлдэггүй. Үүний гол шалтгаан нь томчуудад итгэх итгэл алдарсан эсвэл мэдээлэх нь үр дүнгүй гэж үздэгтэй холбоотой.
- 200 өсвөр насныхны нэг нь цахим дарамтаас үүдэлтэй амиа хорлох бодол төрж байсан гэж хариулжээ.
- Сурагчдын талаас илүү хувь нь сургуулиасаа цахим дарамтын талаарх боловсрол аваагүй байна.

Мөн эцэг эх, сургуулиудын зүгээс цахим дээрэлхэлтийг таньж мэдэх, урьдчилан сэргийлэх, зохих арга хэмжээ авах чадавхи сул байгаа нь анхаарал татаж байна. Олон эцэг эх хүүхдийнхээ интернет хэрэглээг хянахад бэрхшээлтэй тулгарч, цахим платформуудын насны шаардлагын талаар мэдлэггүй байдаг. Үүнээс гадна, сургуулиуд

ч мөн адил сурагчдадаа цахим дарамтаас сэргийлэх боловсрол олгох, шаардлагатай нөөц боллоцоогоор хангах тал дээр хангалтгүй ажиллаж байна.

## Цахим дээрэлхэлтийн хор уршиг ба үр нөлөө

Цахим орчны дарамт нь Монгол Улсад төдийгүй дэлхий даяар залуучуудын сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлдэг. Энэхүү судалгаа нь цахим орчны дарамт нь сэтгэл гутрал, нойргүйдэл, сурлагын амжилт буурах зэрэг олон сөрөг үр дагаварт хүргэдгийг илрүүллээ.

Хүүхдүүд, өсвөр насныхан цахим орчны дарамтад өртөж буйгаа бусдад хэлэхгүй байх, нуухыг илүүд үзэх нь уг асуудлыг улам гүнзгийрүүлж байна. Энэ нь насанд хүрэгчид болон мэдээлэх механизмд итгэх итгэл дутмаг байгааг харуулж байгаа юм.

Байнгын дарамт шахалт нь үе тэнгийнхэн, насанд хүрэгчид болон байгууллагуудад итгэх итгэлийг алдагдуулж, улмаар нийгмээс тусгаарлагдах шалтгаан болдог. Дээрэлхүүлж буй хүүхдүүдийн анхаарал төвлөрөл муудах, урам зориг буурах, сургуульдаа ирэх сонирхол багасах зэрэг шинж тэмдгүүд түгээмэл ажиглагддаг бөгөөд энэ нь сургалтын үр дүнд шууд сөргөөр нөлөөлдөг. Шийдвэрлэхгүй орхисон цахим дээрэлхэлт нь удаан хугацааны турш сэтгэл зүйн шарх үлдээж, өөртөө итгэх итгэлийг бууруулж, насанд хүрсэн хойноо ч тулгарч болох бэрхшээлийг бий болгодог.

## Гол зөвлөмжүүд

Эдгээр дүгнэлтийг харгалзан үзвэл уг тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд олон талт оролцоотой, хамтын ажиллагаатай арга хэмжээг хэрэгжүүлэх нь нэн чухал.

## Одоогийн хууль эрх зүйн орчныг сайжруулах

Монгол Улс Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль болон Кибер аюулгүй байдлын тухай хуулиар

тодорхой ахиц гаргасан ч хууль эрх зүйн зарим цоорхой байсаар байна:

- Тодорхойгүй тодорхойлолтууд: “Цахим дээрэлхэлт” болон “хортой контент”-ын хүрээг илүү нарийвчлан тодорхойлох шаардлагатай бөгөөд ингэснээр хууль хэрэгжилт жигд, тууштай явагдана.
- Жендерт суурилсан, технологид суурилсан хүчирхийлэл: Одоогийн хууль эрх зүйн хүрээнд хүйсийн онцлогт суурилсан дарамт, цахим орчин дахь зориуд чиглэсэн доромжлолыг хангалттай хэмжээнд зохицуулаагүй.
- Мэдээлэх болон хариу арга хэмжээ авах механизм: Хуульд хэрэглэгчдэд ээлтэй, нууцлал хангасан мэдээлэх сувгууд болон цахим үйлчилгээ үзүүлэгчид, боловсролын байгууллагуудад заавал биелүүлэх хариу арга хэмжээний хугацааг тодорхой заагаагүй.
- Дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хууль эрх зүйн үүрэг: Боловсролын байгууллага болон бусад үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг хохирогчдыг сэтгэл зүйн дэмжлэгт хамруулах талаар хуульчлан тусгаагүй.
- Мэдээлэл цуглуулах, ил тод байдал: Цахим дээрэлхэлтийн статистикийг стандартчилах, нийтлэх, хуваалцах бодлого сул хөгжсөн байна.

### **Дижитал боловсролыг сайжруулах: Ур чадварыг тодорхойлох ба зорилтот хөтөлбөрүүд**

Дижитал боловсрол нь цахим орчны аюулгүй байдал болон цахим дээрэлхэлтийн урьдчилан сэргийлэлтийн гол тулгуур юм. Үүнд эцэг эхчүүдэд зориулсан боловсролын материал, сурагчдад зориулсан цахим дээрэлхэлтийн талаарх мэдлэг, дижитал боловсролын хөтөлбөрүүд, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, мөн сургууль, олон нийтийн дунд мэдээлэх, дэмжих тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай. Эдгээр хүчин чармайлт нь ерөнхий мэдээллээс илүүтэйгээр бодит ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгдэх ёстой:

#### **Сурагчдад зориулсан ур чадварууд:**

- Цахим дээрэлхэлтийг таньж, хариу үйлдэл үзүүлэх
- Нууцлалын тохиргоо болон дижитал хувийн мэдээллээ аюулгүй ашиглах
- Онлайн контент болон эх сурвалжийг

шүүмжлэлтэй үнэлэх

- Сэтгэл хөдлөлийн зохицуулалт ба цахим маргааныг шийдвэрлэх стратеги
- Аюулгүй мэдээлэх сувгуудын талаарх мэдлэг

#### **Эцэг эхчүүдэд зориулсан мэдлэг:**

- Цахим орчны эрсдэл болон социал медиа платформуудын бодлого (жишээлбэл, насны хязгаарлалт)
- Эцэг эхийн хяналт болон нууцлалын хэрэгслийг үр дүнтэй ашиглах
- Хүүхдүүдтэйгээ цахим туршлагын талаар итгэлтэй, нээлттэй харилцах
- Цахим дээрэлхэлт болон сэтгэл зүйн хямралын шинж тэмдгийг таних

Үүнээс гадна, эцэг эх болон хүүхдүүдийн хооронд цахим аюулгүй байдлын талаар ил тод, тасралтгүй харилцаа үүсгэх, итгэлцлийг бий болгох нь чухал. Сургуулиуд цахим дээрэлхэлтийн боловсролыг хичээлийн хөтөлбөртөө нэгтгэж, сурагчдыг дижитал орчныг хариуцлагатай, тэсвэртэй ашиглах мэдлэг, ур чадвараар хангах шаардлагатай.

### **Насанд тохирсон хөтөлбөрүүд:**

**Хүүхдүүд (9–12 нас):** Насанд нь тохирсон, цахим орчинд аюулгүй байдлыг хангасан, буруу, сөрөг үр дагавартай харилцааг таних, хэзээ, хэрхэн тусламж хүсэх тухай төвлөрсөн хөтөлбөрүүд. Үүнд:

- Комик, тоглоом, түүх ашигласан богино хэмжээний анги танхимын модулиуд.
- Онлайн аюул заналыг таних, тусламж хүсэх дасгалууд.
- Сургуулиудад тараах флаш карт ашиглан мэдээлэхийг уриалах.
- Багш нар болон сургуулийн сэтгэл зүйчидтэй хамтран эрт илрэх шинж тэмдгүүдийг хянах.

**Өсвөр насныхан (13–17 нас):** Дижитал боловсрол, хувийн мэдээллийн хамгаалалт, үе тэнгийн дэмжлэгийн стратеги, сэтгэцийн эрүүл мэндийн тэсвэр тэвчээрийг хөгжүүлэх. Залуусын удирдлага дор явагдах семинар хөтөлбөрүүд нь сурагчдыг цахим аюулгүй байдлын практик мэдлэг, манлайллын ур чадварт сургаж чадна. Өсвөр насныханд зориулсан хөтөлбөрүүдэд дараах зүйлс багтаж болно:

- Цахим хамгаалагч хөтөлбөр: Сонгогдсон сурагчдыг дижитал хамгаалагчаар бэлтгэх.
- “Өөрчлөлтийн төлөө хакатон”: Сурагчдын санаачилсан цахим эрсдэлтэй тэмцэх төслүүд (апп, кампанит ажил, видео).
- Сургууль, олон нийтийн төвүүдэд зохион байгуулах цахим аюулгүй байдлын мэтгэлцээн, семинарууд.
- Нууцлалтай мэдээлэх хэрэгсэл (биет болон дижитал), мөн мэдээлсний дараа юу болох талаарх зааварчилгаа.
- Онлайн стресс болон үе тэнгийн дарамтыг даван туулах анхаарал төвлөрөл ба тэсвэр тэвчээрийн семинарууд.

**Эцэг эхчүүдэд зориулсан:** Дижитал эцэг эхийн сургалт, технологийн хэрэглээ болон харилцааны арга барилын гарын авлага, нөөц материалууд.

- Сар бүрийн “Дижитал эцэг эхийн тойрог”: Сургуулиас зохион байгуулдаг эцэг эхчүүдийн хэлэлцүүлэг.
- Гарын авлага: Хувийн нууцлал, платформууд болон хүүхдүүдтэйгээ харилцах тухай зурагт гарын авлага.
- Долоо хоног бүрийн SMS зөвлөмжийн систем: Технологийн мэдлэг багатай өрхүүдэд ч хүртээмжтэй богино хэмжээний эцэг эхийн зөвлөгөө мессежээр илгээнэ.
- Эцэг эхийн боловсролыг сургуулийн чиг баримжаа олгох уулзалтыг эцэг эхийн хуралтай нэгтгэх.

**Багш нарт зориулсан:** Цахим дээрэлхэлт, дижитал бичиг үсэг тайлагдалт болон хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн талаарх заавал судлах жил тутмын мэргэжлийн хөгжлийн сургалтыг багшийн сургалтад оруулах. Анги танхимд зориулсан хэрэгслийн багц болон хариу арга хэмжээний журам боловсруулах.

- Жил бүрийн мэргэжлийн хөгжлийн гэрчилгээ: Бүх багш нарт цахим дээрэлхэлт, сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж болон хариу арга хэмжээний талаар заавал суралцах сургалт.
- Ангийн хэрэгслийн багц: Үндэсний боловсролын стандартад нийцсэн слайд, тараах материал болон дасгалууд.
- Сургууль бүрт цахим аюулгүй байдлын асуудал хариуцсан багш томилох (“Цахим аюулгүй байдлын төв цэг”) – эрт илрүүлэлт болон сурагчдыг чиглүүлэх зорилготой.
- Хичээлийн төлөвлөгөөнд дижитал аюулгүй байдлыг бүх хичээлд тусгах (жишээ нь: ёс зүй, мэдээллийн технологи, уран зохиол).

## **Сэтгэл зүйн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах**

Цахим дээрэлхэлтийн сэтгэл зүйн нөлөөг харгалзан, олон салбарын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай:

- Сургуулиуд болон магадлан итгэмжлэгдсэн сэтгэл зүйн эрүүл мэндийн байгууллагуудын хооронд албан ёсны чиглүүлэх тогтолцоо бий болгох (Улаанбаатар хотод 6 сарын дотор туршилтаар эхлүүлж, 18 сарын дотор улс даяар өргөжүүлэх).
- Цахим болон биечлэн үзүүлэх дэмжлэгийн үйлчилгээг хамтран хөгжүүлж орон нутгийн залуучууд болон гэр бүлд хүртээмжтэй байхаар зохион байгуулах. Үүнд тусламжийн утас, чат дэмжлэг, сургуульд суурилсан зөвлөх үйлчилгээ зэргийг багтаах боломжтой.
- Багш, эцэг эхчүүдэд зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламжийн талаархи тогтмол сургалт, зөвлөгөөг мэргэжлийн сэтгэл зүйн эрүүл мэндийн байгууллагуудаар дамжуулан хүргэх.

## 9. УРИАЛГА

---

Цахим дээрэлхэлт нь Монголын ирээдүй хойч үеийнхэнд нөлөөлж буй тулгамдсан хямрал юм. Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд асран хамгаалагчид, сурган хүмүүжүүлэгчид, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд, орон нутгийн удирдлагууд мөн бодлого тодорхойлогчид зэрэг олон талын оролцогчдын хамтын ажиллагаа шаардлагатай. Энэхүү судалгаанд дэвшүүлсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхийн тулд үр дүнтэй хамтран ажилласнаар Монгол Улс залуу үеэ хамгаалж, аюулгүй цахим орчинг бүрдүүлэх чиглэлд томоохон ахиц гаргаж чадна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр Монгол дахь аюулгүй, хүртээмжтэй цахим орчныг хөгжүүлэхэд тууштай дэмжлэг үзүүлсээр байх болно. Энэхүү судалгааны үр дүн, зөвлөмжүүд нь ирээдүйн санаачилга, хамтын ажиллагааны үнэтэй суурь болно. Цахим дээрэлхэлтийн асуудлыг нэн тэргүүнд тавьж, шаардлагатай нөөц, арга хэмжээнд хөрөнгө оруулснаар Монголын хүүхэд, өсвөр насныхан цахим болон бусад орчинд аль алинд нь аюулгүй, хөгжих боломжтой болно.

## НОМ ЗҮЙ

- (EPRS), E. P. (2025). Бүс нутгийн болон орон нутгийн түвшинд цахим дээрэлхэлтэй тэмцэх нь. [https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2025/775857/EPRS\\_BRI\(2025\)775857\\_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2025/775857/EPRS_BRI(2025)775857_EN.pdf).
- (RISCS), R. I. (2025). Цахим дээрэлхэлтийн тайлан. <https://bpb-eu-w2.wpmucdn.com/blogs.bristol.ac.uk/dist/3/939/files/2025/03/RISCS-Cyberbullying-report-2025-Nerida-Brand.pdf>.
- Бадрах А. болон бусад. (2023). Монгол өсвөр насныхны сэтгэлзүйн сайн сайхан байдал, асуудалтай нийгмийн сүлжээний хэрэглээ ба цахим дээрэлхэлтийн оролцоо. <https://link.springer.com/article/10.1007/s42380-023-00202-9>.
- Судалгааны төв, Пью Рисерч. (2022). Өсвөр насныхан ба цахим дээрэлхэлт. <https://www.pewresearch.org/internet/2022/12/15/teens-and-cyberbullying-2022/>.
- CLG, Грейстоуны хотын баг, Ирланд. (2023). Энэ бол бүхэл бүтэн тосгоны ажил – Ирланд. <https://www.ittakesavillagegreystones-delgany.com/>.
- Косталес Ж. болон бусад. (2022). Их дээд сургуулийн оюутнуудын профайл ба цахим дээрэлхэлтийн тархалт: Шинэ хэвийн сургалтын үр дагавар. <https://dl.acm.org/doi/abs/10.1145/3545862.3545896>.
- Эспалаге ДЛ болон бусад. (2016). Цахим дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх ба хөндлөнгөөс оролцох хүчин чармайлтууд: Одоогийн мэдлэг ба ирээдүйн чиг хандлага. <https://journals.sagepub.com/doi/10.1177/0706743716684793#core-bibr58-0706743716684793-1>.
- Хиндужа, С. (2018). АНУ-ын дунд болон ахлах ангийн сурагчдын дунд цахим дээрэлхэлт: Тархалт, нөлөөлөл ба хөндлөнгөөс оролцох нь. *Journal of Adolescent Health*, 63(1), 121–127.
- Санаачилга, Тогтвортой хөгжлийн. (2021). Хүүхэд хамгааллын системийн зураглалын үнэлгээний тайлан. <https://mn.usembassy.gov/wp-content/uploads/sites/192/ADAPT-eng-full.pdf>.
- Сэтгүүл, Глобал Пресс. (2023). Монгол улс онлайн орчинд шилжихийн хэрээр луйвар нэмэгдэж байна. <https://globalpressjournal.com/asia/mongolia/scams-skyrocket-mongolia-goes-online/>.
- Ли, Q. (2014). Цахим дээрэлхэлт ба өсвөр насны сэтгэл гутралын хоорондын хамаарал. *Journal of Youth and Adolescence*, 43(3), 472–482.
- Боловсрол, сургалтын яам, Вьетнам. (2009). Найрсаг сургуулиуд ба идэвхтэй сурагчдыг бий болгох хөтөлбөр. <https://vwu.vn/tin-chi-tiet/-/chi-tiet/vietnam-women-s-union-signed-a-coordinated-program-building-friendly-schools-and-active-students--10779-604.html>.
- Боловсролын яам, Малайз. (2013-2025). Малайзын боловсролын цэнхэр хөтөлбөр. <https://www.pmo.gov.my/wp-content/uploads/2019/07/Malaysia-Education-Blueprint-2013-2025.pdf>.
- Сингапурын Боловсролын яам. (2014-2025). Кибер сайн сайхан байдлын хөтөлбөр. <https://www.moe.gov.sg/education-in-sg/our-programmes/cyber-wellness>.
- Монгол Улсын Засгийн газар. (2022). Кибер аюулгүй байдлын тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390365491061>.
- Монгол Улсын Засгийн газар. (2022). Үндэсний кибер аюулгүй байдлын стратеги. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532522791411>.
- Монгол Улсын Засгийн газар. (2022). Хувийн нууцыг хамгаалах тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390288615991>.
- Монгол Улсын Засгийн газар. (2024). Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140463602711>.
- Парк, М. С-А болон бусад. (2021). Зүүн Азийн өсвөр насныхны кибер дээрэлхэлтийн нийгэм-соёлын үнэт зүйлс, хандлага болон эрсдэлт хүчин зүйлсийн системчилсэн тойм. <https://cyberpsychology.eu/article/download/11615/32665/59252>.

- Руангнапакулетал Н. болон бусад. (2019). Зүүн Өмнөд Азийн орнууддахь кибер дээрэлхэлтийн системчилсэн шинжилгээ. <https://www.ijitee.org/wp-content/uploads/papers/v8i8s/H10200688S19.pdf>.
- Тайланд, The Nation. (2018). Кибер дээрэлхэлтийг бууруулахад салбар хоорондын хамтын ажиллагаа шаардлагатай. <https://www.nationthailand.com/tech/30341702>.
- Турку, KiVa хөтөлбөр ба Турку Их Сургууль. (2006). KiVa. <https://www.kivaprogram.net/what-is-kiva/>.
- UNDRR. (2020). Кибер дээрэлхэлт. <https://www.undrr.org/understanding-disaster-risk/terminology/hips/tl0026>.
- UNICEF. (2013). Хүүхэд хамгаалал. <https://www.unicef.org/mongolia/child-protection>.
- UNICEF. (2024). Кибер дарамт: Энэ нь юу вэ, үүнийг хэрхэн зогсоох вэ. <https://www.unicef.org/stories/how-to-stop-cyberbullying>
- Европын Холбоо. (2023). TABASCO төсөл. <https://www.tabasco-erasmus.eu/objectives/>
- Уиллард, Н.С. (2007). Кибер дарамт ба өөртөө итгэх итгэл. *Psychology of Popular Media Culture*, 1(2), 18–29.

